

АМИЙН УС

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН МАТЕРИАЛ

Дараах судрын хэсэг, мэдэгдлүүдийг уншаад, Есүс Христийн өгдөг амийн усны талаарх ойлголтыг олж мэд.

- Иохан 4:13–14
- Иохан 7:37–38
- 2 Нифай 9:50–51
- 3 Нифай 20:8–9

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ийн заасан.



[Иохан 4:10]-т дурдагдсан амийн ус бол Их Эзэн Есүс Христийг, мөн Түүний сайн мэдээг хэлж байгаа юм. Амьдралыг ус тэтгэгдийн адил мөнх амьдралыг хүлээн авахад Аврагч, Түүний сургаал, ёслолууд амин чухал. Сүнслэг өсөлт, хөгжлөө тэтгэхэд та болон би Түүний амийн уснаас өдөр бүр, хангалттай хүртэх хэрэгтэй.

Судрууд нь Христийн үгийг агуулдаг бөгөөд энэ нь хүссэн үедээ, удаан хугацаанд, шимтэн залгиж болох амийн усны нөөц юм. Та бид 'амийн усны усан оргилуур' болох Христ рүү харж, ариун судруудад агуулагдсан Христийн үгсийг (1 Нифай 11:25; Ифер 8:26; 12:28-тай харьцуул) уншиж (Мозая 1:5-ыг үзнэ үү), суралцаж (Сургаал ба Гэрээ 26:1-ийг үзнэ үү), судалж (Иохан 5:39; Алма 17:2-ыг үзнэ үү) мөн үүн дээр найрласнаар (2 Нифай 32:3-ыг үзнэ үү) Түүн дээр ирэх ёстой. Ингэснээр бид мөнх бус аялынхаа явцад сүнслэг удирдамж, хамгаалалт хүлээн авна. (David A. Bednar, "A Reservoir of Living Water" [Church Educational System fireside for young adults, Feb. 4, 2007], 1, broadcasts.ChurchofJesusChrist.org)

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жозэф Б.Вертлин (1917–2008) ийн заасан.



Олон хүн Есүс Христийн сайн мэдээний найрын ширээнд суудаг ч өмнө нь тавьсан зоогоос ам хүрэх төдий амсдаг. Тэд магадгүй

дадаж сурснаараа цуглаанд сууж, судраа харсан төдий болж, нөгөө л нэг залбирлаа давтаж байж болох ч зүрх сэтгэл нь алсын холд байдаг. Хэрэв тэд шударгаар хэлэх байсан бол Ариун Сүнсний бурханлаг гайхамшиг, гайхалтай тохинууллын оронд хөрш айлын талаарх сүүлийн үеийн цуу яриа, хувьцааны зах зээлийн чиг хандлага, өөрсдийн дуртай ТВ-ийн шоуг илүү их сонирхож байгаагаа хүлээн зөвшөөрөх байсан.

Та нар энэ амийн уснаас хүртэж, мөнх амьдралд хүргэх бурханлаг булаг та нарын дотор бургилан оргилж буйг мэдрэхийг хүсэж байна уу?

Тэгвэл бүү ай. Бүх зүрх сэтгэлээрээ итгэ. Бурханы Хүүд итгэх гуйвшгүй итгэлийг хөгжүүл. Чин сэтгэлийн залбирлаар зүрх сэтгэлээ уудлан илчил. Түүний тухай мэдлэгээр оюун ухаанаа дүүргэ. Сул талаа орхи. Цэвэр ариун байж, зарлигуудад нийцүүлэн амьдар. (Joseph B. Wirthlin, "The Abundant Life," *Ensign* эсвэл *Liahona*, May 2006, 100)

Эдгээр эх сурвалжаас сурч мэдсэн зүйл дээрээ тулгуурлан хэлэх үгийнхээ тоймыг гаргаж эхлээрэй. Та тоймдоо дараах асуултуудад хариулсан байхад анхаар. Мөн хэлэх үгэндээ Есүс Христийн талаарх бодол санаагаа хэрхэн илэрхийлэхээ бод. Аврагчийн амийн уснаас хүртэж байсан хувийн туршлагаа мөн тэдгээр нь хэрхэн танд нөлөөлсөн тухай хуваалцаж болох юм.

- Есүс Христийн өгдөг амийн ус нь юу вэ?
- Яагаад бидэнд Аврагчийн амийн ус хэрэгтэй вэ?
- Бид Аврагчийн амийн уснаас хүртэхийн тулд юу хийж болох вэ?
- Аврагч хүн бүрийг амийн уснаас нь хүртээсэй хэмээн хүсдэг болохыг мэдэх нь Түүний талаарх таны бодол санаанд хэрхэн нөлөөлж байна вэ?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ